



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 9/92

Ховд

Г Улаан загалмайн гишүүнээр элсүүлэх тухай Т

Монголын Улаан загалмайн Нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.2, 8.6.2, 8.6.3 дахь заалт, Монголын Улаан Загалмайн Нийгэмлэгийн дүрмийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төр Улаан загалмайн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газар, Улаан загалмайн хороотой хамтран ажиллах үйл ажиллагааныхаа хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын азрын ажилчдыг гишүүнээр элсүүлсүгэй.

2. Гишүүнээр элсүүлэх ажлыг хариуцаж гишүүний бүртгэл гаргаж гарын үсэг зуруулан Улаан загалмайн хороонд хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн /С.Дорж/-д үүрэг болгосугай.

3. Гишүүний татвар болох 10000 төгрөг /Арван мянган/-ийг 3 дугаар сарын цалингаас хураан авч аймгийн Улаан загалмайн хорооны дансанд төвлөрүүлж ажиллахыг Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД

